

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/53/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: Azzaya.Ts@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>НББББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагараа баг Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ӨНӨРХАН ТАНАА

2021.02.08 № 2/33
Тамгай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



021020285

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17054027.0</u>	<u>36889178.0</u>
33	АВЛАГА	3359515.0	16300756.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	861495.0	53416.0
335	Бусад авлага	2498020.0	16247340.0
3351	Байгууллагаас авах авлага	2498020.0	16247340.0
35	БАРАА МАТЕРИАЛ	13694512.0	20588422.0
354	Хангамжийн материал	13694512.0	20588422.0
35410	Бичиг хэргийн материал	734500.0	971810.0
35420	Аж ахуйн материал	10322012.0	14601612.0
35430	Сэлбэг хэрэгсэл	1100000.0	1152000.0
35440	Түлш, шатах тослох материал	1285000.0	3680000.0
35470	Бусад хангамжийн материал	253000.0	183000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2094969175.2</u>	<u>3039770768.4</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2094969175.2	3039770768.4
392	Биет хөрөнгө	2091034425.2	3036137768.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	316527457.9	1289538346.9
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21492015.4	-49684436.8
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122808950.0	76328950.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81837699.9	-43190849.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78950900.0	94532063.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-55400854.7	-61761156.1
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12173695.0	23993595.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11570580.0	-10655073.3
39209	Зам, гүүрийн байгууламж	147691900.0	199275260.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-81601470.1	-88291502.1
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1100000.0	1100000.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	2089380363.0	2122230363.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-425696220.7	-517277791.3
393	Биет бус хөрөнгө	3934749.9	3632999.8
39301	Програм хангамж	3380500.0	1707000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2287750.1	-916000.2
39303	Бусад биет бус хөрөнгө	2842000.0	2842000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2112023202.2</u>	<u>3076659946.4</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>984580.0</u>	<u>69328.9</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	984580.0	69328.9
413	Өглөг	984580.0	69328.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	817700.0	69328.9
4136	Бусад өглөг	166880.0	0.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	166880.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2111038622.2</u>	<u>3076590617.6</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	2111038622.2	3076590617.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	316383597.0	316383597.0
51101	Өмч: - төрийн	316383597.0	316383597.0
512	Хуримтлагдсан үр дүн	1665030824.1	2630582819.5
51210	Өмнөх үеийн үр дүн	1665030824.1	1665030824.1
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	965551995.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129624201.1	129624201.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2112023202.2</u>	<u>3076659946.4</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	592389210.0	1537161464.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	223878076.0	1026200848.0
120	Нийтлэг татварын бус орлого	223878076.0	1026200848.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	223878076.0	1026200848.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50000.0	363500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	2000000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	223828076.0	1023837348.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368511134.0	510960616.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48826134.0	121890116.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45884634.0	105716664.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2941500.0	16173452.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319685000.0	389070500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289518600.0	375560500.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30166400.0	13510000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	462734582.3	571879468.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462734582.3	571879468.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461354082.3	551807104.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200494461.0	247934621.0
210101	Үндсэн цалин	200220811.0	193303208.0
210102	Нэмэгдэл	273650.0	54631413.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23313060.0	31130680.7
210201	Тэтгэврийн даатгал	14751337.1	21644294.4
210202	Тэтгэмжийн даатгал	2628721.0	2479458.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1591514.9	1983566.7
210204	Ажилгүйдлийн даатгал	394680.8	455194.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3946806.3	4568166.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13270752.0	17908374.0
210301	Гэрэл, цахилгаан	2113942.0	3520774.0

210302	Түлш, халаалт	11156810.0	14387600.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21510833.0	20682190.0
210401	Бичиг хэрэг	3293245.0	3021690.0
210402	Тээвэр, шатахуун	14399908.0	14561700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3817680.0	3098800.0
2105	Нормативт зардал	552000.0	402000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	552000.0	402000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9283950.0	4200700.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	50000.0	150000.0
210604	Урсгал засвар	9233950.0	4050700.0
2107	Томилолт, зочны зардал	6596256.0	2728000.0
210702	Дотоод албан томилолт	6596256.0	2728000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37068683.0	68800250.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36316333.0	67368250.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260000.0	260000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	332350.0	275000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22000.0	30000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	450000.0
210807	Газрын төлбөр	138000.0	147000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149264087.3	158020288.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19632520.0	11958970.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	4314500.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	129631567.3	141746818.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1380500.0	20072364.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1380500.0	14910327.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	14649600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1380500.0	260727.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	5162037.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	5162037.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>129654627.7</u>	<u>965281995.4</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1690490.5	0.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1690490.5	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1690490.5	0.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>127964137.3</u>	<u>965551995.4</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>368561134.0</u>	<u>513324116.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50000.0	2363500.0
120	Нийтлэг татварын бус орлого	50000.0	2363500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50000.0	2363500.0

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50000.0	363500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	2000000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368511134.0	510960616.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48826134.0	121890116.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45884634.0	105716664.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2941500.0	16173452.0
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319685000.0	389070500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289518600.0	375560500.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30166400.0	13510000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	334562134.0	458855252.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334562134.0	458855252.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330194114.0	422530547.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198931500.0	247359494.8
210101	Үндсэн цалин	136915075.0	156308162.0
210102	Нэмэгдэл	35433200.0	48055432.8
210105	Гэрээт ажлын хөлс	26583225.0	42995900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24866400.0	31471041.0
210201	Тэтгэврийн даатгал	17108300.0	22001791.0
210202	Тэтгэмжийн даатгал	1781000.0	2324600.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1591400.0	1895250.0
210204	Ажилгүйдлийн даатгал	407000.0	477600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3978700.0	4771800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17416800.0	20343600.0
210301	Гэрэл, цахилгаан	2887200.0	3426620.0
210302	Түлш, халаалт	14529600.0	16916980.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18854100.0	21204600.0
210401	Бичиг хэрэг	3208900.0	3199000.0
210402	Тээвэр, шатахуун	12201300.0	14561700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3443900.0	3443900.0
2105	Нормативт зардал	402000.0	402000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402000.0	402000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4336700.0	12250000.0
210602	Тавилга	0.0	10000000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200000.0	150000.0
210604	Урсгал засвар	4136700.0	2100000.0
2107	Томилолт, зочны зардал	6621100.0	2728000.0
210702	Дотоод албан томилолт	6621100.0	2728000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43594114.0	69596412.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42631969.0	68434412.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.0	260000.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	275000.0	275000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30000.0	30000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	219145.0	450000.0
210807	Газрын төлбөр	138000.0	147000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15171400.0	17175400.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15171400.0	12860900.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	4314500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4368020.0	36324704.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1870000.0	14915327.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	14649600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1870000.0	265727.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	21409377.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	21409377.2
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2498020.0	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2498020.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33999000.0</u>	<u>54468864.0</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33999000.0	54468864.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33999000.0	54468864.0
2200	Дотоод эх үүсвэрээр	33999000.0	54468864.0
222001	Тоног төхөөрөмж	33999000.0	7725500.0
223001	Бусад хөрөнгө	0.0	46743364.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-33999000.0</u>	<u>-54468864.0</u>

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	1,662,532,804.1	2,108,540,602.2
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	1,662,532,804.1	2,108,540,602.2
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	968,068,014.7	968,068,014.7
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	1,665,030,824.1	2,111,038,622.2
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	1,665,030,824.1	2,111,038,622.2
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	1,665,030,824.1	2,111,038,622.2
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	965,551,995.4	965,551,995.4
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,383,597.0	129,624,201.1	2,630,582,819.5	3,076,590,617.6

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	394973600.0	386271962.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387248100.0	378546462.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372323500.0	363631135.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251764100.0	247359494.8
210101	Үндсэн цалин	159286900.0	156308162.0
210102	Нэмэгдэл	49481300.0	48055432.8
210105	Гэрээт ажлын хөлс	42995900.0	42995900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33988200.0	31471041.0
210201	Тэтгэврийн даатгал	23917600.0	22001791.0
210202	Тэтгэмжийн даатгал	2517700.0	2324600.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2014100.0	1895250.0
210204	Ажилгүйдлийн даатгал	503500.0	477600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5035300.0	4771800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20639300.0	20343600.0
210301	Гэрэл, цахилгаан	3687200.0	3426620.0
210302	Түлш, халаалт	16952100.0	16916980.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21204600.0	21204600.0
210401	Бичиг хэрэг	3199000.0	3199000.0
210402	Тээвэр, шатахуун	14561700.0	14561700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3443900.0	3443900.0
2105	Нормативт зардал	402000.0	402000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402000.0	402000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2300000.0	2250000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200000.0	150000.0
210604	Урсгал засвар	2100000.0	2100000.0
2107	Томилолт, зочны зардал	3229900.0	2548000.0
210702	Дотоод албан томилолт	3229900.0	2548000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21577000.0	20877000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20415000.0	19715000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260000.0	260000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275000.0	275000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30000.0	30000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450000.0	450000.0
210807	Газрын төлбөр	147000.0	147000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17218400.0	17175400.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12903900.0	12860900.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4314500.0	4314500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14924600.0	14915327.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14924600.0	14915327.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14649600.0	14649600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275000.0	265727.0

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7725500.0	7725500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	7725500.0	7725500.0
222001	Тоног төхөөрөмж	7725500.0	7725500.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394973600.0	386271962.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	392368600.0	383908462.8
132001	Орон нутгийн төсвөөс	378858600.0	370398462.8
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	13510000.0	13510000.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2605000.0	2363500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605000.0	363500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.0	2000000.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.0	27.0
620001	Удирдах ажилтан	8.0	8.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.0	9.0
620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0
620004	Гэрээт ажилтан	7.0	7.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121890116.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75146752.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58899412.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10000000.0
210602	Тавилга	10000000.0
2107	Томилолт, зочны зардал	180000.0
210702	Дотоод албан томилолт	180000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48719412.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48719412.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16247340.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16247340.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46743364.0
2200	Дотоод эх үүсвэрээр	46743364.0
223001	Бусад хөрөнгө	46743364.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121890116.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121890116.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105716664.0

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Х.Өнерхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч төсвийн хөрөнгийн зарцуулалт, авлага, НБББББ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 02-ноос 2021 оны 02 дугаар сарын 07-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ЗДТГ нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Тухайн шатны хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Ховд сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг 2016-2019 оны үйл ажиллагаанд хяналт хийгдэж нийт 20926.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 6250.9 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 14675.4 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж бичсэн байна.

Өгсөн 6250.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэн ажилсан байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 459354.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3869.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1537161.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 15371.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 964636.7 мянган төгрөгөөр буюу 45.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	3359.5	16300.7	12941.2	385.2%
Бараа материал	13694.5	20588.4	6893.9	50.3%
Үндсэн хөрөнгө	2094969.1	3039770.7	944801.5	45.1%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2112023.2	3076659.9	964636.7	45.7%
Богино хугацаат өр төлбөр	984.5	69.3	-915.2	-93%
Цэвэр хөрөнгө, өмч	2111038.6	3076590.6	965551.9	45.7%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2112023.2	3076659.9	964636.7	45.7%

Авлага дансны үлдэгдэл 16300.7 мянган төгрөг болж 12941.2 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой аймгийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлсэн 9997.5, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зардал 1081.3, өвс тэжээлийн фонд байгуулах 2498.0, газрын дуудлага худалдааны 1730.5, цахим тендерийн хураамж 940.0 мянган төгрөг нийт 16247.3 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

2020 оны эцэст нэмэлт данснаас төвлөрүүлсэн 16247.3 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, цалингийн урьдчилгаа суутгахгүйгээр олгосонтой холбоотойгоор 54.3 нийт 16300.7 төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20588.4 мянган төгрөг болж 6893.9 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд шинэ байранд орсонтой холбоотой аж ахуйн материалын эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4279.6 мянган төгрөгөөр өссөн, 32 тн нүүрсний нөөц бүрдүүлсэн зэргээс тус тус шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2094969.1 мянган төгрөг, оны эцэст 3039770.7 мянган төгрөг болж 944801.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 973010.8 мянган төгрөгөөр нутгийн удирдлагын ордон, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянбулаг багийн өндөр хүчдэлийн трансформатор 29850.0 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар тавилга хэрэгсэл авахад 13245.0 мянган төгрөг, Мерси кор ОУБ-аас Улааны арын худгийн засвар 10333.5, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Баянбулаг багийн Шар хөтлийн эхэн худаг 22331.7 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч хөрөнгө нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 127 тоот, 115 тоот тогтоолоор 2 нэр төрлийн 46480.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсан, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 27 тоот тогтоолоор 13 нэр төрлийн 3376.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталснаар хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр оны эхэнд 984.5 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг байсныг барагдуулан ажиллаж оны эцэст 69.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3076590.6 мянган төгрөг болж тайлант онд 965551.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Ховд сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 944772.2 мянган төгрөгөөр буюу 259.4 хувиар өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тамгын газрын барилга хүлээн авсан нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 944772.2 мянган төгрөгийн орлогоос 86041.9 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 800009.2 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 108874.8 мянган төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 47440.1 мянган төгрөг буюу 23.6 хувиар, тогтмол зардал 4637.6 мянган төгрөг буюу 34.9 хувиар, бусад урсгал шилжүүлэг 18691.8 мянган төгрөг буюу 1454.0 хувиар өссөн, хангамж бараа материалын зардал 828.6 мянган төгрөг буюу 4.0 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 5083.2 мянган төгрөг буюу 221.0 хувиар, томилолтын зардал 3868.2 мянган төгрөг буюу 241.8 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 305308.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 305308.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10/03 тоот тогтоолоор ЗДТГ-ын 2020 оны төсвийг 394973.6 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 394973.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 378858.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 13510.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 2605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 370398.4 мянган төгрөг, ОНХС-аас 13510.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 2363.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 386271.9 мянган төгрөгийг зарцуулж 8701.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 356271.9 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь дотоод томилолтын зардлыг 681.9 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 295.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 700.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 43.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2517.1 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 4404.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээ 8701.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой хог хаягдал орчны бохирдол, биеийн тамир уралдаан тэмцээн зэрэг арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7153.4
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	79.3
80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	1047.8
80305	Биеийн тамир уралдаан тэмцээн	43.0
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	85.0
82212	Хур хог хаягдал орчны бохирдол	161.1
72208- 80103	Ахмад настны хөгжил хамгаалал	132.0
	ДҮН	8701.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн хөрөнгө оруулалтаар Ховд сумын ЗДТГ-т тавилга, тоног төхөөрөмж 19997.5, аймгийн ОНХС-аас ЕБС дотуур байрны хатуу эдлэл 28310, Баянбулаг багийг цахилгаанаар холбох 27825.3, Шинээр худаг гаргах 18918.0, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зардал 1081.3, Статистикийн хэлтсээс судалгааны ажлын зардалд 4906.4, аймгийн Онцгой байдлын газраас 180.0, Ковид-19 цар тахлын санхүүжилт 4429.7, ХХҮГ-аас ахмадын баярын санхүүжилт 2000.0, цахим тендерийн хураамж 840.0, хүү торгуулийн орлого 8675.1, оны эхний үлдэгдлээс 2498.0, барьцаа дэнчин дуудлага худалдааны орлогоос 2128.5 мянган төгрөг нийт 121890.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс орон сууц хүн амын тооллого, хагас жилийн мал тооллогын судалгааны зардалд 4906.4 мянган, Ховд сумын ЗДТГ-т тавилга, тоног төхөөрөмж авахад 10000.0 мянган төгрөг, ЕБС дотуур байрны хатуу эдлэл авах зардалд 28310, ахмадын баярын үйл ажиллагааны зардал 2000.0 мянган төгрөг, хууль бусаар ан агнасан мэдээлэгчийн зардалд 810.0, Баянбулаг багийг цахилгаанаар холбох 27825.3, Шинээр худаг гаргах 18918.0, сонгуулийн хэсгийн хороонд ажилласны томилолт 180.0 мянган төгрөг, онцгой нөхцөлд ажилласан ажилчдын хоолны үнэ 120.4 мөн Ковид-19 цар тахлын хандив 4429.7, өөрийн орлого 4590.0 мянган төгрөгийг үндсэн данс руу шилжүүлж, үлдэгдэл 16247.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 29 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Мөн нэмэлт дансаар орсон гарсан гүйлгээний талаар мэдээлээгүй. Батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг тус тус мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 50.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.8 сая төгрөгийн алдааг залруулж, 49.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	49.8	1	49.8	0	0	100
Нийт дүн	1	49.8	1	49.8	0	0	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10997.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10997.5 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 10997.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар шатахууны зарцуулалтанд тавих дотоод хяналтын үр дүнтэй байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБОТОЙ АСУУДАЛ /АВЛАГА/

1.1. **Илрүүлэлт:** Вива зоне ХХК-тай байгуулсан тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний биелэлт хангагдаагүй байхад гүйцэтгэл гаргаж үлдэгдэл санхүүжилтийг нэмэлт дансандаа авсан бөгөөд оны эцэст 9997.5 мянган төгрөгийг татуулснаар авлага нэмэгдсэн байна. Өмнөх оны 808.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага барагдаж, өвс тэжээлийн фонд байгуулах 2498.0 мянган төгрөг орж ирсэн боловч татуулж дахин авлага үүсгэсэн байна. Тайлант онд нэмж гамшгаас хамгаалах

өндөржүүлсэн бэлэн байдлын зардал 1081.3, газрын дуудлага худалдааны орлого 1730.5, цахим тендерийн 940.0 мянган төгрөгийг тус тус татуулж авлагаар бүртгэсэнтэй холбоотой өссөн байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, гэрээний үүргийн биелэлт хангагдахгүй байх

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж 2021 онд багтааж авлага, өглөгийг барагдуулах, Вива зоне компанитай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, гэрээнд алданги тооцох заалт оруулах.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ.**

2.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Эрсдэл: Бодлогын баримт бичиггүйгээс санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

2.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж мөрдөх.

2.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. **ЗАРДЛЫН ДАНСНЫ ТАЛААР.**

3.1 Илрүүлэлт: 2007, 2008 оны газрын төлбөр төлөөгүй хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан иргэдтэй холбоотой 1000.0 мянган төгрөгийн актын төлбөрийг Санхүүгийн хяналт аудитын албаны нэмэлт санхүүжилтийн данс руу төсвөөс төлж үр ашиггүй зардал гаргасан байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх.

3.2 Өгсөн зөвлөмж: Иргэн, албан тушаалтантай холбоотой тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж үргүй зардал гаргахгүй байх, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэлд авлага өглөгөөр тусгаж хэвших.

3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4. **ШАТАХУУНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР.**

4.1 Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтын норм баримтлаагүй, бусдын машинд хийсэн шатахууны тооцоо бодсон баримт засвартай, жолоочийн тооцоо, замын хуудас эмх цэгцгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”. “13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх.

4.2 Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцоо, замын хуудсыг иж бүрэн гаргаж /шатах тослох материал/, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

4.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

5. **ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

5.1 Илрүүлэлт: Тайлант онд Шилэн дансны нэгдсэн программд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дугаар заалтыг зөрчиж байна.

Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх.

5.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж баталгаажуулж хэвших. Нэмэлт дансны орлого зарлагын мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлэх.

5.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр:	Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/53/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ховд сумын Засаг даргын тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлага нэмэгдүүлсэн.	9997.5	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Х.Өнөрхан Т.Ернур
2	НББББ боловсруулж баталж мөрдөөгүй.	-	Зөвлөмж өгөх		
3	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан иргэдийн актын төлбөр барагдуулж үргүй зардал гаргасан.	1000.0	Зөвлөмж өгөх		
4	Шатахуун зарцуулалтын норм баримтлаагүй, бусдын машинд хийсэн шатахууны тооцоо бодсон баримт засвартай, жолоочийн тооцоо, замын хуудас эмх цэгцгүй.	0	Зөвлөмж өгөх		
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаагүй.		Зөвлөмж өгөх		
ДҮН		10997.5			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР